

СҮМДЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 08 сарын 18

Сүмдүн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилгыг өлүүлэхэд чиглэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, хүрсэн түвшинг төлөвлөсөн срилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан гүйцэтгэлийн үр дүнг залэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн бодлого, төлөвлөлтөд тусгах, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад явцын хяналт-шинжилгээний зорилго оршино.

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ**

Сүмдүн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны өлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажиллав.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-т заасан ага зүйгээр явцын хяналт шинжилгээ хийхдээ сумдаас ирүүлсэн тайланд нийтлэсэн хийсэн.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны өлөвлөгөөний хэрэгжилтэд эхний 8 сарын байдлаар явцын хяналт шинжилгээ ийллээ.

Сумдаас ирүүлсэн тайлан нь тоо баримтгүй, шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түвшиндээ хүрсэн эсэх нь тодорхой, шалгуур үзүүлэлтийн дагуу зайлганаагүй зэрэг хангалтгүй тайлан ирүүлсэн нь гүйцэтгэлийн үнэлгээг журмын дагуу гаргах боломжгүй байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу гаргаж үнэлгээг журмын 6.2.1-т заасан ага зүйгээр

Дүгнэх. 1 заалтын биелэлтийг бүрэн тайлагнаагүй алдаа гаргасан тохиолдолд ийлбэр үнэлгээ буруу гарна гэдгийг анхаарах хэрэгтэй.

Төлөвлөлт, тайлагналтыг өмнөх жилээс Говь-Угаал, Баянжаргалан, Луус, Элгэрцогт, Сайнцагаан сумууд сайжруулсан байна. Хулд, Дэрэн, Эрдэнэдалай, Элгэрхангай, Адаацаг, Өндөршил, Гурвансайхан сумууд тайлан хангалтгүй рүүлсэн бөгөөд төлөвлөлт, тайлангаа сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

Цагаандэлгэр, Сайхан-Овоо, Өлзийт сумууд тайлангаа ирүүлээгүй тул зцын хяналт шинжилгээг хийгээгүй болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт гаргах загвар хүснэгтүүд Засгийн эрүүн 2021 оны 374 дүгээр тогтоолын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан тул мөрдөж ажиллах шаардлагатай байна. Мөн Дэлгэрцогт, Хулд, Адаацаг, Сайнцагаан сумууд excel файлаар тайлан ирүүлэхгүй байх талаар анхаарах цэрэгтэй.

Тиймээс Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг сумын төгэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулан дүгнүүлэхээс өмнө дараах звлөмжийг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.

## НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг ирүүлэхдээ нэгдсэн тайлангаас гадна тайлангийн танилцуулга хийж ирүүлж хэвших

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 жилийн төлөвлөгөөнөөс тухайн жилийн төлөвлөгөөг гарган Засаг даргаар батлуулах

Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтолтувшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой баримтжуулан тайлагнах

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-т заасан арга зүйгээр үнэлгээг зөв хэрэглэх

1 шалгуур үзүүлэлттэй 1 арга хэмжээний үнэлгээг гаргахдаа 2 шалгуур үзүүлэлтийг журмын дагуу үнэлээд дунджаар нь гаргах

Зарцуулсан хөрөнгийн хэмжээг заавал бичих

Үугацаа болоогүй байгаа болон 50 хувиас доош хэрэгжилттэй байгаа тасарч болзошгүй буюу 0 хувьтай байгаа зорилт, арга хэмжээнүүдийг эрчимжүүлж эжиллах, холбогдох төсвийн байгууллагуудад чиглэл өгөх

Хөтөлбөрийн хүрээнд үр дүнтэй хийгдсэн ажлуудыг орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч сурталчлах ажлыг зохион байгуулах

Хөтөлбөрийн ерөнхий үнэлгээг гаргахдаа Зорилт, арга хэмжээ 2-ыг тусад чь дунджийг нь гарган хооронд нь нэмж 2 хуваан гаргана. /зорилтын дундаж арга хэмжээний дундаж /2/

Жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд орох тул ирүүлж байгаа тайлангийн чанарт анхаарах

ХЯНАСАН :

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА Г.САМДАНЦООДОЛ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН: Туслахад албан ёсны 3548

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН *Д.ДААРИЙМАА*